

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
"Чингис хаан Үндэсний баялгийн сан" ХХК
2025 оны бүтэн жилийн байдлаар

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
ЗГ-ын тогтоол					
45	75	Үндэсний баялгийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_42	1. 1 ."Чингис хаан Үндэсний баялгийн сан"-ийн төрөлжсөн сангийн хөрөнгийн менежментийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах, сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компанийн хэлбэрээр байгуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), Гүйцэтгэх захирал (С.Наранцогт)-д тус тус даалгасугай.	"Чингис хаан Үндэсний баялгийн сан" ХХК-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 15 дугаар тогтоолоор үүсгэн байгуулсан ба 16 дугаар тогтоолоор компанийн дүрмийг, 17 дугаар тогтоолоор компанийн үйл ажиллагааны төсвийг баталж, 2025 оны бизнес төлөвлөгөөг 1 дүгээр улиралд багтаан хэлэлцүүлэхийг даалгасан. Үүний дагуу 2025 оны Бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулж, 3 дугаар сарын 28-ны өдрийн 1/018 дугаар албан бичгээр Эрдэнэс Монгол ХХК-д хүргүүлсэн. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор "Чингис хаан Үндэсний баялгийн сан" ХХК-ийн бүтэц орон тоог 2 газар, 2 алба, 1 нэгжтэй, орон тооны дээд хязгаарыг 27 байхаар баталсан бөгөөд Захиргаа, удирдлагын газар, Төрөлжсөн сангуудын бодлого, зохицуулалтын газар, Санхүүгийн удирдлага, бодлогын алба, Олон нийттэй харилцах алба болон Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх нэгж (Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Үндэсний баялгийн сангийн хуульд заасан стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох хэлэлцээртэй холбоотой болон иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх) гэсэн батлагдсан бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.	100
	76		2. 2 .Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан дахь иргэний дансны мөнгөн хөрөнгийг цахим системээр өөрт нь ил тод тайлагнаж, иргэдийн хөрөнгөө удирдах боломжийг бүрдүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), Гүйцэтгэх захирал (С.Наранцогт)-д тус тус үүрэг болгосугай.	2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу иргэн бүрт хуримтлалын нэрийн дансны бүртгэл хөтөлж эхэлсэн. Нэрийн дансанд бүртгэгдсэн ногдол ашгийн мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийн профайл цэсний "Чингис хаан Үндэсний баялгийн сан" цэсэнд оруулж, ашиглалтад оруулснаар иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг харах боломжтой болсон. Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2024 оны 2 болон 3 дахь удаагийн хувьцааны ногдол ашгаа Хуримтлалын санд хуримтлуулах хүсэлт гаргасан 4,026 иргэний И-Монголиа систем дэх "Чингис хаан Үндэсний баялгийн сан" цэсэнд мэдээллийг шинэчлэн оруулав.	100
78	140	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	6.8.2. Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны ногдол ашгийг иргэнд хуваарилах ажлыг шуурхай хэрэгжүүлж, Хуримтлалын санд шилжүүлэх асуудлаар иргэдээс санал авах арга хэмжээ зохион байгуулахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов."(Үндэсний баялгийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай)	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 6 дугаар хуралдаанаас өгөгдсөн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн дунд И-Монголиа цахим системээр дамжуулан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас авах ногдол ашгаа бэлэн мөнгөөр хувийн харилцах дансандаа авах, хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлж авах, эсхүл Нийслэлийн дэд бүтэц, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хандивлах гэсэн гурван сонголттой санал асуулгыг 2025 оны 2 дугаар сарын 19-ны өдрөөс 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Санал асуулгад нийт 505,318 иргэд оролцож, оролцогсдын 4.4% буюу 22,242 хүн "Хуримтлалын санд хандивлах" гэсэн хариулт өгсөн. Уг 22,242 хүний дунд 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдөр баталгаажуулах санал асуулгыг явуулахад 20,088 буюу 94.4% сонголт баталгаажуулаагүй, 615 буюу 2.9% "Тийм" буюу ногдол ашгийг Хуримтлалын санд төвлөрүүлэх, 575 буюу 2.7% "Үгүй" гэсэн хариулт өгсөн. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 3 дахь удаагийн ногдол ашгийг хэрхэн хүлээн авах тухай санал асуулгыг "И-Монголиа" цахим системээр дамжуулан 2025 оны 4 дүгээр сарын 4-нөөс 15-ны өдрийн хооронд хоёр үе шаттай явуулж, 3,426 иргэн Хуримтлалын санд, 70 иргэн Хөгжлийн санд хандивлахаар сонгосон. Хуримтлалын санд хуримтлуулахаар санал өгсөн 4,026 иргэний 342,566,151.45 төгрөгийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн Монголбанканд байрших нэрийн данс руу шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Компанийн 2025 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд цаашид энэ төрлийн судалгаа, санал асуулгын хамрах хүрээг өргөтгөж зохион байгуулахаар оруулсан. "Эрдэнэс Тавантолгой" ХК ногдол ашиг хуваарилахтай холбогдуулан төрийн цахим үйлчилгээний И-Монголиа системээр авсан санал асуулгын талаар олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэх зорилгоор С-1, Боловсрол телевизэд мэдээлэл өгч, Үндэсний баялгийн сангийн социал хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх контент бэлдэж нийтэлсэн.	100
141	142		9.24.2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахдаа бэлнээр авах, хуримтлуулах, эсхүл хандивлах эсэх талаар иргэдийн дунд санал асуулга явуулж, үр дүнд үндэслэн иргэдийн сонголтын дагуу ногдол ашгийг олгох арга хэмжээ зохион байгуулахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн), гүйцэтгэх удирдлага (Х.Мөнхжаргал)-д, ("Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах асуудлын талаар)	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 9 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хүрээнд явуулсан санал асуулгын "Та цаашид Эрдэнэс Тавантолгой ХК-ийн өөрийн эзэмшил дэх хувьцааны ногдол ашгийг ямар хэлбэрээр хүлээн авах хүсэлтэй байгаа вэ?" гэсэн асуултанд Хуримтлалын сан, Хөгжлийн санд төвлөрүүлэх хариулт өгсөн иргэдийн дунд И-Монголиа цахим системээр 2025 оны 2 сарын 27-ноос 3 сарын 5-ны хооронд баталгаажуулалт хийсэн. Баталгаажуулалтын үр дүнд 600 иргэн Хуримтлалын сан дахь нэрийн дансандаа шилжүүлж, 15 иргэн Хөгжлийн санд хандив өргөхөөр болсон. Үүний дагуу Сангийн яам, Монголбанктай зөвлөлдөж, ТТХА дээр зохион байгуулалт хийж ажиллав. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 3 дахь удаагийн ногдол ашгийг хэрхэн хүлээн авах тухай санал асуулгыг "И-Монголиа" цахим системээр дамжуулан 2025 оны 4 дүгээр сарын 4-нөөс 15-ны өдрийн хооронд хоёр үе шаттай явуулж, 3,426 иргэн Хуримтлалын санд, 70 иргэн Хөгжлийн санд хандивлахаар сонгосон. Хуримтлалын санд хуримтлуулахаар санал өгсөн 4,026 иргэний 342,566,151.45 төгрөгийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн Монголбанканд байрших нэрийн данс руу шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.	100
			9.24.2.2. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн олгосон ногдол ашгийг иргэд хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх болон төрөлжсөн сан хооронд шилжүүлж хуримтлуулах, арвижуулах нөхцөл боломжийг судлан үзэж, холбогдох зохицуулалтыг бий болгох чиглэлээр зохих шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, "И-Монгол академи" УТҮГ-ын захирал (Б.Мягмарнаран), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д;	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн олгосон ногдол ашгийг иргэд хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх болон төрөлжсөн сан хооронд шилжүүлж хуримтлуулах, арвижуулах нөхцөлийг судлах ажлыг "Чингис хаан Үндэсний баялгийн сан" ХХК-ийн 2025 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган тандан судалгаа болон хэрэглэгчийн судалгааг хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогын шийдлүүдийг Монголбанк, Сангийн яам, ЗГХЭГ, ЭТТ, Э-МГЛ талуудтай зөвлөлдөж, ЗГХЭГ даргад бодлогын шийдэл, гаргалгаа танилцуулсан. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах эсэхээр ЗГХЭГ шийдвэр гаргамагц, тандан судалгаа болон дараагийн алхмуудыг хэрэгжүүлнэ.	100

79	143	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-02-19 Дугаар 2025_09</p>	<p>9.24.2.3. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг виртуал карт, хадгаламжийн дэвтэр болон бусад хэлбэрээр иргэдэд хүргэх асуудлыг судалж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, "И-Монгол академи" УТУГ-ын захирал (Б.Мягмарнаран), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д;</p>	<p>Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны хуримтлалын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх үүднээс виртуал карт, хадгаламжийн дэвтэр ашиглах асуудлыг судалж, хэрэгжүүлэхээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, ЗГХЭГ даргад танилцуулсан. Төрийн банктэй зөвлөлдөж, карт, хадгаламжийн дэвтрийн дизайн эх бэлтгэсэн. Мөн карт, дэвтрийг нэвтрүүлэх талаар видео сурталчилгаа хийж, социал хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.</p>	100
79	144	<p>9.24.2.4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл орд, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тэдгээрээс төвлөрүүлсэн орлого, үр өгөөжийн хуваарилалт, ашиглалтын талаар иргэд, олон нийтэд нэгдсэн ойлголт, мэдээлэл хүргүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д;</p>	<p>Засгийн газрын 2025 оны 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчөөр Ж.Батзанданг томилж, ажиллах нөхцөлөөр хангахыг "Эрдэнэс Монгол" ХХК-д даалгасны дагуу Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын албыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр "Чингис хаан Үндэсний баялгийн сан" ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилсон. БЭТ-ийн ажлын алба дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 35 дугаар "Ажлын дэд хэсгийг шинэчлэн байгуулах тухай" тушаалаар Ерөнхий сайдын Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Ажлын дэд хэсгийг шинэчлэн байгуулсан ба Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч Ж.Батзандан ахлан ажиллаж байна. Ажлын дэд хэсгийн эхийн хуралдаанд Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Н.Учралаас өгсөн тодорхой чиглэлийн дагуу стратегийн ордод ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах саналын хувилбарыг боловсруулж танилцуулах удирдамжийг баталсан. Ажлын дэд хэсгийн хуралдааныг өргөтгөсөн байдлаар 3 удаа (2025.03.11, 2025.03.20, 2025.05.05), хэсэгчилсэн байдлаар 6 удаа зохион байгуулсан. Мөн дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулаад байна. Энэ хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагаас албан ёсны танилцуулга мэдээлэл авах, салбарын мэргэжлийн эрдэмтэд судлаачдаас зөвлөгөө авах, хууль эрх зүй, санхүүгийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авахад шаардлагатай ажлын даалгавар боловсруулах зэрэг ажил хийгдэж байна. Дотоод зохион байгуулалт, бэлтгэл ажил хангагдсаны дараа хил зааг тодорхой болсон, олборлолт явуулж буй стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Нийт стратегийн 12 орд дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч буй 27 компанитай хэлэлцээ хийхээр байна. 2025 оны 5 дугаар сарын 5-ны байдлаар 16 компанид хэлэлцээг эхлүүлэхээр албан бичиг боловсруулж урилга хүргүүлснээс 7 ААН-тэй Бүрэн эрхт төлөөлөгч уулзалт хийсэн. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Батзандан 2 удаа (2025.02.20, 2025.04.14) хэвлэлийн бага хурал, Төрийн ордонд 4 удаа хэвлэл мэдээллийн байгууллагад (2025.02.19, 2025.03.31, 2024.04.14, 2025.05.12) мэдээ, 1 удаа телевизийн нэвтрүүлэгт (NTV телевизийн "Лхагвын тойм" нэвтрүүлгийн 55 дахь дугаар 2025.04.16) оролцон, 9 удаа сайтад мэдээлэл өгч, өөрийн фэйсбүүк хуудсаар 20 удаа иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Мөн Үндэсний баялгийн санг сурталчилж, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл орд, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тэдгээрээс төвлөрүүлсэн орлогыг Үндэсний баялгийн санд хуримтлуулах, үр өгөөжийг олон нийтэд сурталчлан таниулах, нэгдмэл ойлголт өгөх зорилгоор бүрэн хэмжээний нэвтрүүлэг 1, контент 1-ийг бэлтгэснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн. Телевиз болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон газрын хэвлийн баялгийг ашиглах, түүний үр өгөөжийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна. "Эрдэнэс Тавантолгой" ХК ногдол ашиг хуваарилахтай холбогдуулан төрийн цахим үйлчилгээний И-Монголиа системээр авсан санал асуулгын талаар олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэх зорилгоор С-1, Боловсрол телевизэд мэдээлэл өгч, Үндэсний баялгийн сангийн социал хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх контент бэлдэж нийтэлсэн.</p>	100	